



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/Н/5

Улаанбаатар хот

Ажил хүлээн авах комисс томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийн 351.1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Чингис хаан" Олон улсын нисэх буудлын Агаарын хөлгийн зогсоолд гэрэлтүүлэг байгуулах ИНЕГ/ЦА/ТББ/А-10/15 дугаар гэрээт ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:	Д.Мөнхбаатар	"Чингис хаан" Олон улсын нисэх буудлын захирал
Нарийн бичгийн дарга:	П.Сүхболд	Худалдан авах ажиллагааны хэлтсийн Гүйцэтгэлийн тасгийн аэродромын инженер
Гишүүд:	Б.Эрдэнэбаатар	"Чингис хаан" Олон улсын нисэх буудлын Цахилгаан, агааржуулалтын албаны ерөнхий инженер
	А.Амгалан	Техник хангалт, навигацийн үйлчилгээний албаны Гэрэл суултын тасгийн ахлагч инженер
	Ц.Дөлгөөн	Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны нягтлан бодогч

2. Дээрх ажлыг гэрээнд заасан тоо хэмжээ болон техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагуудын дагуу шалгаж хүлээн авах, комиссын акт, холбогдох бусад материалыг бүрдүүлж, Худалдан авах ажиллагааны хэлтэст хүргүүлэхийг Комиссын дарга /Д.Мөнхбаатар/-д даалгасугай.

